



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 11245.

Улаанбаатар хот

Хөрөнгө хоёрдогч түүхий эдээр
худалдах тухай

Монгол улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын дүрмийн 4.1.1, 4.1.2, 7.1.1-дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт 1998 онд баригдсан цэвэрлэх байгууламжийн бохир усны шугам, сүлжээг данс бүртгэлд бүртгэж аваагүй, хариуцах эзэнгүй байдлаас 26 жил газарт булаастай, ашиглалтгүй байж чанар байдлаа алдаж цаашид ашиглах боломжгүй тухай мэргэжлийн байгууллагын хариу ирсэн, Үнэлгээ тогтоох комиссын 2024 оны 08 дугаар сарын 09-ы өдрийн 24/01 тоот шийдвэр гарсан тул хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсугай.

2.Дахин ашиглах боломжгүй хөрөнгийг худалдан борлуулж олсон орлогыг Нийслэлийн төсөвт төвлөрүүлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, Төлөвлөлт, Санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500329